



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 07 сарын 14 өдөр

Дугаар А/456

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.2.12, 41 дүгээр зүйлийн 41.2.2 заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны “Аймгийн 2019 оны төсөв батлах тухай” 8/04 дүгээр тогтоолыг тус, тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Чөлөөт бөхийн спортын төрлөөр амжилт гаргаж 2018 оны дэлхийн аваргын хүрэл медаль хүртсэн Ховд аймгийн харъяат олон улсын хэмжээний мастер Баатаржавын Шоовдорын амжилт бүтээлийг тэмдэглэн цаашдын бэлтгэл сургуулилалт, дасгалжуулалтын ажилд 3 500.0 мянган төгрөг /Гурван сая таван зуун мянган/-ийг дэмжлэг болгон олгосугай.

2.Тус арга хэмжээнд зарцуулах 3 500.0 мянган төгрөгийг аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний жагсаалтын 5.17 дахь заалтын “Спортын аварга хөтөлбөр”-өөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Даваадорж/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт тус тус зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ